



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

157

Г Бодлогын баримт бичиг
батлах тухай

Төрийн болон орон нутгын өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Мэдээллийн технологийн үндэсний паркын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Мэдээллийн технологийн үндэсний паркын Оюуны өмчийн бодлого"-ыг хавсралт ёсоор баталсугай.


Хоёр. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гарган ажиллахыг Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төв /П.Наранцэцэг/-д даалгасугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулж байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар /Г.Ганцэцэг/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.МЯГМАРНАРАН



Мэдээллийн технологийн үндэсний Паркын
Ерөнхий захирлын 2015 оны 11 сарын 22 өдрийн
139 тоот тушаалтын хавсралт

“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК”-ЫН ОЮУНЫ ӨМЧИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Оюуны өмч нь улс орон, аж үйлдвэрийн салбар, салбарын аж ахуйн нэгжийн хөгжлийг эрчимжүүлэх, мэдлэгт сууринсан эдийн засгийн үндсийг тавих гол хүчин зүйлсийн нэг мөн.
- 1.2. Мэдээллийн технологийн үндэсний парк /цаашид “Парк” гэх/-ын Оюуны өмчийн талаар баримтлах бодлого /цаашид “Бодлого” гэх/ нь аж үйлдвэр, шинжлэх ухаан, технологи, инновацийн талаархи төрийн бодлоготой уялдах бөгөөд оюуны өмчийн соёлыг төлөвшүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулахыг дэмжих замаар өндөр технологи, соёлын аж үйлдвэрийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах хамтын ажиллагааны таатай нөхцлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг тодорхойлоход чиглэнэ.
- 1.3. Энэхүү бодлогын баримт бичиг нь Паркын технологи дамжуулах, технологи нутагшуулах стратегийн зорилтыг хэрэгжүүлэхтэй уялдана.

ХОЁР. БОДЛОГЫН ЗАРЧИМ

- 2.1. Бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.1.1 Оюуны өмчийн харилцаанд оролцогч талууд (Парк, оюуны өмч бүтээгч/зохиогч болон түншлэгч/гуравдагч этгээд)-ын харилцааг зохицуулахдаа эрх тэгш, нээлттэй, шударга ёсыг эрхэмлэх;
 - 2.1.2 Паркын нийгэмд үзүүлэх үйлчилгээний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь шинэ мэдлэг технологи дамжуулах бөгөөд үйл ажиллагаанаас олох орлогыг холбогдох журмын дагуу саадгүй хуваарилах;
 - 2.1.3 Паркд бий болсон технологиос гадна Эрдэм шинжилгээний байгууллага, аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хувь хүн бүтээсэн, хөгжүүлсэн технологийг дамжуулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагааг дэмжих;
 - 2.1.4 Оюуны өмчийн харилцаанд оролцогч талууд (Парк, оюуны өмч бүтээгч/зохиогч болон түншлэгч/гуравдагч этгээд)-ын эрх ашгийг харилцан хүндэтгэж, эрх, үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тодорхой болгож хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих;

2.1.5 Оюуны өмчийн харилцаатай уялдан гарах сонирхолын зөрчлөөс сэргийлэх;

ГУРАВ. БОДЛОГЫН ЗОРИЛГО

3.1. Бодлогын зорилго нь оюуны өмчийн соёлыг төлөвшүүлэх, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах цогц үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

ДӨРӨВ. БОДЛОГЫН ЧИГЛЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

4.1. Бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.

4.1.1 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой харилцааг хөгжүүлэх хамтын ажиллагааны таатай нөхцлийг бүрдүүлэх;

4.1.2 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах тогтолцоог хөгжүүлэх;

4.1.3 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад оролцогч хүний нөөцийг бэлтгэх;

4.2. Бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх дараах арга хэмжээг авна.

4.2.1 Оюуны өмчтэй холбоотой харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны таатай нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр

4.2.1.1 Оюуны өмчийн соёл нэвтрүүлэх, хөгжүүлэх

4.2.1.2 Оюуны өмч буюу шинэ мэдлэг, технологи бүтээх, тэдгээрийн ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих;

4.2.1.3 Шинэ мэдлэг, технологийг дамжуулах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бусдын оюуны өмчийн эдийн болон эдийн бус баялгийн эрхийг хүндэтгэх;

4.2.1.4 Парк үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үед, эсвэл хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон оюуны өмчийн эдийн засгийн эрх эзэмшигчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тодорхойлох, эрхийг нь хүндэтгэх;

4.2.1.5 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулснаас олох орлогоос хуримтлал үүсгэж, судалгаа хөгжүүлэлт, гарааны бизнес, энтрепренёрийг дэмжих;

- 4.2.2 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр
- 4.2.2.1 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах цогц ажиллагааг зохицуулах Технологи дамжуулах журам боловсруулж, мөрдүүлэх;
 - 4.2.2.2 Оюуны өмч, технологи дамжуулах, арилжих дэд бүтэц, тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэхийг дэмжих;
 - 4.2.2.3 Оюуны өмчийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих;
 - 4.2.2.4 Оюуны өмчийг зах зээлд нэвтрүүлснээс олсон орлогыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шударгаар хуваарилах;
- 4.2.3 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад оролцогч хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр
- 4.2.3.1 Оюуны өмчтэй холбоотой хүний нөөцийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
 - 4.2.3.2 Оюуны өмчийн чиглэлээр сургалт зохион байгуулах, мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдахыг дэмжих;

ТАВ. БОДЛОГЫН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 5.1 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулж, баялгийг нэмэгдүүлэх нөхцөл бий болно.
- 5.2 Оюуны өмчийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ ихэсч, эдийн засгийн үр ашиг дээшилнэ.
- 5.3 Оюуны өмч бүтээгч, эзэмшигч, ашиглагч, хэрэглэгчид эдийн болон эдийн бус баялгийн үр шим хүртэнэ.
- 5.4 Зах зээлд өрсөлдөх чадвар бүхий оюуны өмч, технологи, судалгаа хөгжил, аж үйлдвэр, санхүү, борлуулалтын сүлжээ бүрэлдэн хөгжиж мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд дэмжлэг болно.
- 5.5 Паркын хэмжээнд оюуны өмчийн удирдлагын эрх зүйн орчин бүрдүүлэхэд энэхүү бодлогын үндэс болгоно.
- 5.6 Парк нь оюуны өмчийн бодлогын хөтөлбөр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ба холбогдох журмуудыг боловсруулж мөрдөнө.

- 161
- 5.7 Паркын оюуны өмчийн бодлогын дагуу технологийг дамжуулах, түүний үр дүнд бий болсон хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр судалгаа хөгжүүлэлт, гарааны бизнес, энтрепренёрийг дэмжих чиг үүрэг бүхий инновацийн технологийн асуудал хариуцсан нэгжтэй байна.
- 5.8 Инноваци, технологийн асуудал хариуцсан нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг байгууллагын дотоод журмаар зохицуулах ба технологийг үнэлэх, оюуны өмчийн хамгаалалт хийх, үйлдвэрлэлд нэвтрэх боломжтой технологийг сонгох, зах зээлийн боломжийг тодорхойлох, лицензийн гэрээг байгуулах болон арилжих, технологи дамжуулалтаас олох орлогыг хуваарилах, инновацийн гарааны компани байгуулж ажиллуулах үйл ажиллагааг Паркын “Технологи дамжуулах журам”-аар зохицуулна.
- 5.9 Энэхүү Оюуны өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Паркын удирдлагаар хэлэлцүүлж, Ерөнхий захирлаар батлуулна.